

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Азийн сангийн хооронд байгуулсан 2015 оны “Хамтран ажиллах санамж бичиг”, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг цахим хэлбэрээр буюу гар утасны аппликейшн ашиглан иргэд, олон нийтээс авах ажлыг 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс 4 дүгээр сарын 1-ний өдрийн хооронд нийслэлийн 9 дүүргийн 171 хороонд зохион байгуулсугай.

2.Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан төсөл, арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 31,965,000 /гучин нэгэн сая есөн зуун жаран таван мянга/ төгрөгийг нийслэлийн 2021 оны төсөвт тусгасан “Хотын индекс тооцож сайжруулах үе шаттай арга хэмжээний зардал”-аас санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Н.Наранбаатар/-т зөвшөөрсүгэй.

3.Иргэдийн санал асуулгыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, дүүрэг, хороодын албан хаагч, хэсгийн ахлагч нарыг сургах, иргэдийг мэдээллээр хангах, сурталчилгаа явуулах, санал асуулгын үр дүнд иргэдээс хамгийн олон санал авсан төсөл арга хэмжээнүүдийг нийслэл, дүүргийн 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн төсөлд тусгах ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст, ухаалаг гар утасны аппликейшны систем болон хороодын интернэтийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангаж, албан хаагчдыг сургах ажилд дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийслэлийн Мэдээлэл, технологийн газар /О.Чинзориг/-т тус тус үүрэг болгосугай.

4.Санал асуулгын танилцуулга видеог хянах, олон нийтэд мэдээлэх, хэвлэл мэдээллийг идэвхжүүлэх ажлыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс /Б.Батманлай/-т даалгасугай.

5.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналын ерөнхий асуулгыг хөрөнгө оруулалтын бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хороо, дүүргийн түвшинд боловсруулах, ухаалаг гар утасны аппликейшн ашиглан санал асуулгыг зохион байгуулах ажлуудад дүүрэг, хороодын албан хаагчдыг идэвхтэй оролцуулах, дүүргийн төсвөөс холбогдох зардлыг шийдвэрлэх, хороодын интернэтийн хурдыг нэмэгдүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг холбогдох дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР

Нийслэлийн Засаг даргын 2021 оны
01 дүгээр сарын 28-ны өдрийн
А/38 дугаар захирамжийн хавсралт

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГААС САНХҮҮЖИХ ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛЫГ ИРГЭДЭЭС ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР
БҮЮУ ГАР УТАСНЫ АППЛИКЕЙШН АШИГЛАН АВАХ
АЖЛЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА

/төгрөг/

№	Зардлын нэр	Тоо	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Хороодын хэсгийн ахлагчдын дата нэгж	1,584	20,000	31,680,000.0
2	Apple Store жилийн суурь хураамж	1	285,000	285,000.0
Нийт дүн				31,965,000.0